

ШУУ 3 - 17776
Тай / Тал - 1254 д.2
Гат - 4
Орца - 45

1980 онд байнгын ашиглалтад оруулж байсан



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ-Д**

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Хувьсгалчдын өргөн чөлөө-15,
Нийслэлийн Засаг захиргааны III байр
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-08
<http://www.ub.innspection.gov.mn>,
E-mail: ub_info@innspection.gov.mn

2015.09.12 № 02-07-94/1925
Талай _____ -нм № _____ -т

Барилгын тухай

Тус газрын дэд даргын баталсан "Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" 2015 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 02-02/859 дугаартай удирдамж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захиралын 2015 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 851 дугаартай албан бичгийн дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эмч нарын 2 дугаар байрны барилгын ашиглалтын явцад тус төвийн аж ахуйн менежер Н.Мягмарыг байлцуулан 2015 оны 9 дүгээр сарын 07-ны өдөр шалгалт хийлээ.

Тус дүүргийн эрүүл мэндийн хөгжлийн төвийн эмч нарын 2 дугаар байрны барилга нь 80.0м*14.0м хэмжээтэй 4 давхар өрөгт бүтээцэн хийцтэй шувуун нуруу дээвэртэй барилыг 1980 онд байнгын ашиглалтад оруулж байжээ.

Шалгалтаар Эмч нарын 2 дугаар байрны гадна талын ханын шавар шохой ховхорч унасан, халтартсан, өнгө гундаж муудсан, дотор цахилгааны монтаж гэмтэл ихтэй, илээр цахилгааны утас татахдаа норм стандарт баримтлаагүй, агааржуулалт хэвийн ажилладаггүйгээс хана таваны шавар шохой унаж халтартсан мөөгөнцөртөх нөхцөл бүрдсэн, дотор заслал чимэглэлийн шохой ховхорч унасан, өгөршиж, босоо болон налуу хагарал, ан цав үүссэн нь "Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар" БД31.102.00 дүрмийн 2.4-т заасныг.

Хавалга, цонхны битүүмж алдагдсан хэв гажилт үүссэн, гадна дотор заслал чимэглэлийн өнгө үзэмж гундсан зэргүүд нь барилга, байгууламж инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм БНБД13-04-03-ийн 2.5-т барилга байгууламжийн бүрдэл хэсгийн үр ашигтай ашиглалтын хугацааны хамгийн бага үргэлжлэлийг хүснэгт 2 заасныг, "Барилгын тухай" хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх /Өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь барилга байгууламжийг ус, агаар хөрсний бохирдлоос сэргийлэх, хот байгуулалт, ашиглалтын дүрмийн

Дээр дурьдсан төлөв байдлаас үндэслэн дүгнэх нь:

Баянзүрх дүүргийн 6 дугаар хорооны Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эмч нарын 2 дугаар байрны барилгын одоогийн төлөв байдал ашиглалтын шаардлага хангахгүй нь Засгийн газрын 2009 оны 72 дугаар тогтоолоор баталсан "Барилга ашиглалтын дүрэм"-ийн 2.2.1 дэх /хүний эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөл бүрдүүлэх/, "Барилгын тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх /хүн ажиллаж амьдрах таатай нөхцөл бүрдүүлсэн, түүний эрүүл мэнд сөрөг нөлөөгүй, аюулгүй байдлыг хангасан/ заалтын хэрэгжилтийг хангахгүй байна.

Цаашид барилгын засварын зураг төслийг эрх бүхий байгууллагад боловсруулан баталуулах, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэн актээр хүлээлцэх нь зүйтэй.

БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Ц.Алтансүх

Ц.АЛТАНСҮХ